

“СОЁЛЫН РЕЛЯТИВИЗМ” БА ҮНДЭСТНИЙ СОЁЛ

И. Саруул - МУИС, НШУС, Нийгмийн-Соёлын антропологийн тэнхим

Ш.Ганхуяг - МУИС, НШУС, Философийн тэнхим

Түлхүүр үг: Үнэт зүйл, соёлын релятивизм, үндэстний соёлын онцлог, соёлжилт

XX зууны 40-50-иад онд Европ болон Америкт нийгэм-соёлын антропологийн онол сэтгэлгээний шинэ шинэ чиглэл, сургуулиуд шинжлэх ухаанд нэвтэрчээ. Тэдний дунд “соёлын релятивизм”-ын онолын үзэл баримтлал чухал байр суурь эзэлсэн байна. Бүрэлдэн хөгжсөн үндсэн нөхцөл нь тухайн цаг үеийн европ, америкийн соёлын онол дахь этноцентризмын зарчмыг үгүйсгэн халах шаардлагатай холбоотой үүсчээ. Этноцентризмын зарчим нь өнөөг хүртэл ноёрхсон европ, америкийн үлгэрчилсэн хөгжлийн онолыг загварчлахаас өөрцгүйд хүргэж, европ бус ард түмний бүтээлч соёлыг зэрлэг, бүдүүлэг мэтээр ямагт доромжилсон агуулгатайгаар асуудалд хандуулж, мухардалд оруулж байжээ. Европцентризм, америкцентризмийн үзэл санаа нь хэтэрхий явцуурч, өрөөсгөл хандлагатай, туйлширсан тул соёлын релятивистууд түүнийг гаж буруу, үеэ өнгөрөөж хоцрогдсон онол хэмээн эрс буруушаан шүүмжилсэн байна. Тэд этноцентризмын онолд сөргүүлэн “соёлын релятивизм” буюу “үнэт зүйл”-ийн шинэ сэтгэлгээ, онолын үзэл баримтлалаа дэвшүүлжээ. Соёлын релятивизм онолын ач холбогдол: 1. Ард түмний бүтээсэн буюу бүтээж буй төрөл бүрийн соёлууд нь хөгжлийн түвшин, өвөрмөц онцлогоосоо үл хамаарч цөм адил эрх тэгш болно; 2. Ард түмний соёл бүхэн давтагшгүй (нандин) үнэт соёл, тиймээс өвөр хоорондоо харьцуулашгүй; 3. Тусгаар соёлыг нэгэн загварын нэгдсэн хэмжүүр, үнэлэмжээрээр үнэлж дүгнэх боломжгүй; 4. Соёл бүхэн үндэсний өвөрмөц онцлогтой; 5. Тэдгээр соёл нутаг орны нөхцөл байдалд тохирсон цасан зохицуулалтын тогтолцооны онцлогтой; 6. Соёлууд тус бүрдээ хаалттай нийгмийн оршин тогтнох шинжтэй тул уг өвөрмөц онцлогийнх нь хүрээнд авч үзэх, танин мэдэх ёстой хэмээн тунхагласанд оршино. Энэхүү агуулгаар нь түүнийг бас “үнэт зүйлийн онол” гэж хавсран нэрлэсэн байна.

Соёлын релятивизмын үзэл санааны үндэслэл гэнэт шинээр бий болоогүй, анх XX зууны тэргүүн хагаст тавигдаж эхэлжээ. Нэрт антропологич Франц Баосын бүтээлүүдэд: - “Соёл болгон үнэт зүйл мөн” (1) гэсэн үзэл санаа тавигдаж байснаас түүнийг гарааны хэлэлийг тавьсан ч гэж үздэг. Ю.П. Аверкиевийнхээр бол анх К. Беккер, Ч. Бирз, А. Вагтс нарын бүтээлд тусгагдаж байжээ (2). Мөн Америкийн антропологийн нийгэмлэг дээр энэхүү үзэл санааны арга зүйн зарчмын асуудлууд хэдэнтээ хэлэлцэгдсэн байна. С.А. Гокаревын тэмдэглэснээр 1952 онд Нью Йорк хотноо хуралдсан угсаатан судлаач болон антропологчдын их хурал дээр “соёлын үнэт зүйл” сэдвээр идэвхтэй маргаан өрнөж байжээ (3). Тиймээс соёлын релятивизмын онол сэтгэлгээний үзэл баримтлалууд нь нилээд удаан хугацаанд аажмаар боловсрогдож ирсэн түүхтэй.

Харин Франц Баосын санаа сэтгэлгээг А. Кребер, Р. Бенедикт, М. Херцсковиц нар дэмжиж, залгамжлан хөгжүүлсний үр дүнд соёлын релятивизмын онол үндсэндээ 1950-иад онд боловсрогдож гүйцжээ. Тэдний дундаас М. Херцсковицийн шинжилгээ судалгаа

эмх цэгцтэйгээрээ ялгарч, чамбай боловсрогдсоноороо олон түмэн хийгээд шинжлэх ухаанд алдаршжээ.

Мелвилл Херцковиц (1895-1963) бол америкийн нэрт антропологич эрдэмтэн, алдарт антропологич Франц Баос, Гольденвейзер нарыг залгамжилсан шавь, антропологийн шинжлэх ухаанд “соёлын релятивизм”-ын онолыг үндэслэгчдийн нэг гэж зүй ёсоор тооцогддог билээ. Шинжилгээ судалгааны ажлынхаа гарааг физик антропологийн шинжлэлээр эхэлсэн хэдий ч цаашдаа соёл, соёл судлалын онол сэтгэлгээний зангилаа сэдвүүдэд хандуулж эдийн засгийн антропологи, инкультурацийн сэдвүүдийг гүнзгийрүүлэн нягталсан болно. Түүний бүтээлүүдээс танилцуулбал: “Америкийн негрүүдийн антропометр” (1930), “Суринамын аман зохиол” (1936), “Гаитийн тал нутгийн амьдрал” (1937), “Аккультураци” (1938), “Эгэл ард түмний эдийн засгийн амьдрал” (1940), “Тринидад тосгон” (1947), “Хүн ба түүний бүтээл” (1948), “Соёлын антропологи” (1948), “Соёл судлал” (1952), “Соёлын антропологи” (1955) зэрэг бүтээлүүдээс зарим нь нийтэд түгжээ. Мелвилл Херцковиц бүтээлүүдээрээ дамжуулан тухай цаг үеийн соёлын онолын өрөөсгөл, дутагдалтай, явцуурсан талуудыг шүүмжлэхийн хамт “соёлын релятивизм”-ын онолын талаарх үзэл баримтлалаа нилээд нухацтай дэвшүүлсэн байна.

Эн тэргүүнд баруун европын соёлын онолд европ бус ард түмний соёлыг судлан тайлбарлахад тэргүүлсэн этноцентризмын зарчим буюу европ ба америк центризмын дутагдалтай, явцуурсан, хэт өрөөсгөл талуудыг зааж шүүмжилжээ. Ялангуяа, тэр үеийн соёлын онолд арьстны, газар зүйн, эдийн засгийн үндэслэл бүхий үзлийн зарчмууд ялгарч байсан ба тэдний дутагдлыг эрс үгүйсгэсэн байна. Арьстны тайлбарууд нь төрөл бүрийн соёлыг зөвхөн бодьгалийн бие махбодын тогтолцоогоор, газар зүйн детерменизм нь соёлын өвөрмөц байдлыг гагцхүү хүмүүсийн оршин амьдрах байгалийн хүрээллийн онцлогоор, эдийн засгийн детерменизм нь зөвхөн материаллаг баялаг үйлдвэрлэх арга төдийгөөр соёлыг тодорхойлж байсан нь арга зүйн хувьд явцуу, хязгаармагдмал болохыг нь харуулж, эдгээрээс эгнэгт татгалзах санал дэвшүүлжээ.

М.Херцковиц европ, америкийн этноцентризмын онолд сөргүүлэн “соёлын релятивизмын онол”-ыг санал болгов. Тус онолын үндсэн санаа нь хөгжлийн түвшингөөс үл хамаарч соёл бүхнийг тус тусад нь авч үзэж байх, тэдний үнэт зүйлсийг нь илрүүлэн тогтоохыг чухалчилжээ. Энэхүү үзэл бодлоо М. Херцковиц бас “этнософи” хэмээн нэрлэх болсон нь соёлын антропологийн гүн ухаанч хандлага буюу үндэстний соёлын талаарх шинэ сэтгэлгээ юм гэж тайлбарласан байна.

Хүн төрөлхтний соёлын хөгжил, дэвшлийн асуудалд М.Херцковиц нилээд анхааралтай ханджээ. Хүн төрөлхтний соёлын хөгжил нийтлэг гэсэн онолтой тэрбээр санал огт нийлсэнгүй, тэр тусмаа нэгдсэн хувьсал (эволюци), дэвшлийн (прогресс) чиглэлтэй үзлийг үгүйсгэсэн хийгээд баруун европын хөгжлийн замналыг загварчилсан дэлхийн соёлын түүхийн нийтлэг зүй тогтолтой гэсэн үндэслэлийг бүр ч няцаав. Түүний санаагаар бол соёлын түүхэн хөгжлийн процесс бол тусгаар соёлуудын зэрэгцсэн хөгжил юм. “Хүн төрөлхтөний хамтран амьдрах онцлогийн хувьд соёл бол түгээмэл хүчин зүйл (шинж), харин нутаг орны өвөрмөц соёл бүхэн давтагдашгүй ховор, гайхамшигтай үнэт зүйл болно” (4) гэжээ. Үүнтэй холбоотойгоор түүхэн дэх дэвшлийн асуудлыг нэг тийш шийдвэрлэсэн байна. Төрөл бүрийн соёлын хэв маягуудад тус тус дэвшлийн шалгуурууд байх ёстой. Европын хөгжил дэвшлийн шалгуур, онолын үзлүүд нь харьцангуй, хийсвэр

ойлголт юм. Тэр тусмаа уламжлалт соёлыг өрнөдийн технологээр хөгжүүлэх оролдлого бол эдгээрийг устгах буюу мөхөөхөд хүргэхээс өөрцгүй. Ялангуяа Л.Г. Морганы санал болгосон зэрлэг, бүдүүлэг, соёл иргэншилт гэсэн түүхэн үечлэлийг хатуухан шүүмжилж, энэхүү үечлэл нь эгэл ард түмний соёлд иргэншилд эсрэгцүүлсэн евроцентрист харьцуулалт төдий. Тэгвэл соёлын хөгжил бол салаа чиглэлээр зэрэгцсэн соёлуудын цогц хөгжил мөн гэж үндэслэжээ.

М. Херцковиц соёлын релятивизмын өнцгөөс “соёл” хэмээх ойлголтыг шинжлэн боловсруулсан байна. Америкийн антропологийн уламжлал ёсоор “соёл” хэмээх ойлголтыг “нийгэм” гэсэн ойлголтоос салган зааглаад соёл бол хүмүүсийн амьдрах арга ухаан, нийгэм бол тодорхой хэвшил маягаар хамтран амьдарч буй хүмүүсийн зохион байгуулалтын тогтолцоо юм. Нийгэм бол хүмүүсээс бүрдэнэ, харин соёл бол тухайн нийгмийг бүрэлдүүлж байгаа хүмүүсийн хэвшсэн зан төлөв, сэтгэхүй болно гэж үзжээ (5). Сэтгэлгээний хамгийн дэлгэрэнгүй хувилбараар соёлыг хүмүүсийн оршин амьдрах орчин болно гэж тайлбарлажээ. Ингэхдээ тусгаар соёл бүр давтагшгүй, гайхамшигтай хувилбар, эсвэл загвар юм. Тэр нь тухайн соёлд хэвшин тогтсон уламжлалаар илэрнэ. Уламжлал нь ард түмний соёл дахь үнэт зүйлсийн тогтолцоогоор тодорхойлогдоно. Иймэрхүү үнэт зүйлс нь соёлуудын хооронд харьцуулагдашгүй. Үнэт зүйл уг соёлын хамгийн онцлог шинжүүдтэй байх тул М. Херцковиц түүнийг “соёлын фокус” буюу “соёлын төвлөрөл” хэмээн томъёолжээ. Чухам соёлын төвлөрөлийн үзэл санаа нь түүний харьцуулашгүй үндэслэлийг нөхцөлдүүлнэ. Жишээлбэл, орчин үеийн баруун европын соёлд хүсэл эрмэлзлэл нь техникийн ололт амжилтаа улам боловсронгуй хөгжүүлэхэд зарцуулагдаж байхад өөр ард түмэнд ураг төрөл - овгийн тогтолцоогоо сахин хадгалахад анхаарна. Заримд нь шашин шүтлэг, гүн ухааны сэтгэлгээгээ улам нарийвчлан нягтлах гэх мэт байна.

М.Херцковицийн соёлын релятивизм нь соёлын хөгжлийн асуудалд нухацтай тайлбар өгчээ. Ердийн хувьслын онол, түүний тодруулга болсон “аажмаар” нийгэм дэвших түлхүүр ойлголт нь түүний сэтгэлгээтэй огтхон ч нийцсэнгүй. Хүн төрөлхтний түүхэн хөгжил бол тусгаар соёл, соёл иргэншил хоёрын зэрэгцсэн хөгжлийн нэгдэл юм. Харин түүний эх сурвалж бол соёлын нэгдэл ба хувьсал хоёрын хоршил (нэгдэл) болно. Ямар ч соёлд тогтвортой байдал ба хувьсан өөрчлөлт хамт байдаг. Соёлын ямар ч өөрчлөлт гагцхүү консерватив буюу уламжлалт үнэт зүйлсийнхээ тогтолцоог сахисан нөхцөлд л өрнөх боломжтой. Чухам энэхүү бүтэц нь соёлын хөгжлийн субъект юм. Соёлын өөрчлөлт өрнөхгүй тохиолдолд наанадаж өвөрмөц шинжээ гээх, эсвэл хөгжил буурах, эцэст мөхөхөд хүрч болзошгүй. Үүнгээр тогтвортой байдал ба өөрчлөлтийн динамик тодорхойлогдоно.

М.Херцковицийнхаар соёл бүр давтагдашгүй онцлогтой. Энэ онцлог нь ард түмэн бүхний онцлог үнэт зүйлсийн тогтолцоогоор тодорно. Соёлын үнэт зүйл бол ард түмний хүсэл эрмэлзлэлийн төсөөлөл юм гээд хүний үйл ажиллагааны туршлагатай холбож (адилтгаж) үзжээ.

Соёлуудын харьцуулалтын асуудалд М.Херцковиц ялгаатай талыг нь илрүүлэхээсээ илүүтэй төсөөтэй шинжүүдийг тогтоожээ. Хүн төрөлхтөний соёл нь нийтлэг шинжээр дүүрэн, ард түмэн болгонд янз бүрийн хэлбэрээр илэрсэн ч нийтлэг мөн чанараа алдахгүй сахидаг нь нийгмийн амьдрал хийгээд соёлын янз бүрийн хүрээнд энэхүү зүй тогтол батлагдсаар буй. Тухайлбал: - Эрэгтэй ба эмэгтэйчүүдийн холбоо,

шашны зан үйлт ба цэргийн бүлэглэлүүд, гар урчуудын холбоо зэрэг нь хоорондоо төрөл бус боловч хүмүүсийн орон тоо, хэв маяг, гүйцэтгэх үүргийн хувьд үсэг бичиггүй ба соёл иргэншилт ард түмэн бүхэнд төсөөтэй; - Ард түмний залуучуудаа хүмүүжүүлэх арга барил хэдий ялгагдах боловч бие хүний нийгэмшил, тодорхой соёлын хэв маягт дасан зохицолтын үр ашгийг сайжруулах зорилготой л байна; - Ард түмний урлаг уран сайхан нь янз бүрээр таашаагдавч ёс зүйн сайн сайхан, гоо зүй рүү тэмүүлдгээрээ адилхан.

М.Херцковицийн соёлын антропологийн үзэл баримтлалд инкультурацийн асуудал онцгой байр суурь эзэлжээ. Английн enculturation – соёлжих гэсэн ойлголт. Хүн бүхэн ямар нэгэн тодорхой соёлд соёлжино (эзэмшинэ), түүнийг инкультураци хэмээн томъёолжээ. Тэрхүү соёлын онцлог сэтгэлгээ, үйл ажиллагаа, зан төлөвт соёлжсоноор агуулга тодорхойлогдоно. Гэхдээ инкультурацийг нийгэмшлээс зааглах ёстой. Нийгэмшил нь хүүхэд ахуйдаа нийт хүн төрөлхтөний амьдралын үйл ажиллагааны аргад суралцах явдал юм. Хэрэг дээрээ нийгмийн харилцааны тогтолцоонд инкультураци ба нийгэмшил нь ямар ч түүхэн хэлбэрт зэрэгцэн явагддаг байна.

Инкультураци хэрхэн өрнөх талаар шинжлэх ухаанд хэдэн хувилбар оои. М. Херцковицийнхаар бол инкультурацийн процесс нь хүн хүүхэд насанд хоол идэх, хэл яриа, зан төлөвт суралцах явдлаар эхэлнэ, харин нас бие гүйцэж том хүн болсон хойно тэр нь улам боловсронгуйгаар төлөвшиж үргэлжилнэ. Иймээс инкультурацийн процесст хүүхэд ба насанд хүрэгсэд гэсэн хөгжлийн хоёр төвшинтэйг тогтоожээ. Эл хоёр түвшнээр дамжуулан соёлын өөрчлөлтийн тогтолцоог нээх, тогтворт байдал ба өөрчлөлтийн зохицолдоог гаргах явдал гэж үзжээ. Инкультурацийн эхний түвшин бол соёлын тогтвортой байдлыг хангах механизм юм. Эхний түвшинд байгаа хүний зорилго бол тодорхой соёлын хэм хэмжээ, ёс журам сахих, уламжлал, шашин шүтлэг гэх мэт өмнөх үеийн үндэстний соёлд суралцан эзэмших явдал болно. Энд бодгаль ямар ч сонголтгүй, үзэл бодлоо илэрхийлэх ямар ч эрхгүй байна. Тиймээс М. Херцковиц хүүхдийг тоглогч байхаасаа илүүтэй тоглоом нь байна гэж үзжээ. Инкультурацийн хоёр дахь түвшний онцлог бол хүн соёлын зүйлд суралцах, эс суралцах сонголттой болсонд оршино. Соёлд ямар нэгэн өөрчлөлт оруулах бололцоотой болсон байна. Насанд хүрэгсдийн түвшин бол нийгэм дэх тэгш эрхийн зохицуулалт юм гэжээ. Хоёрдугаар түвшин бол соёл дахь өөрчлөлтийн нөхцлийг бүрдүүлнэ. Ард түмний соёлын зан төлөв, сэтгэлгээг өөрчлөх бололцоотой болгоно. М. Херцковиц инкультурацийг “соёлт хүний нөхөн үйлдвэрлэл” (6) гээд түүнд өөрчлөлтийг хэрэгжүүлэх механизмыг хамааруулжээ.

М. Херцковицийнхаар бол инкультураци нь соёлын релятивизмын цөм ойлголт байна. Түүний мөн чанар нь хүний эргэцүүлсэн бодол түүний туршлагад үндэслэн суурилна, харин туршлагаа хүн бүр эзэмшсэн соёлынхоо (инкультурацийн) нэг томъёоллын хүрээнд сэтгэж тайлбарлана. Янз бүрийн соёлын цаг хугацаа, холын зай, жин хэмжээ (размер) гэсэн физик ертөнцийн ойлголт төсөөллүүд ч хамарч, тухайн соёлын өнцгөөс тайлбарлагддаг билээ. Тухайлбал, баруун ба зүүн европын цаг хугацааны мэдрэмж хоорондоо ялгагддаг байдаг.

Урьд өмнө Рут Бенедикт санал болгож байсан ч М. Херцковиц соёлын хэм хэмжээний шинэ релятивист шалгуурыг дэвшүүлсэн байна. Эцсийн эцэст юу нь зөв буруу хэвийн ба хэвийн бус байх нь тухайн соёлын зохион байгуулалтаас л хамаарч тогтоогддог юм (7). Европ ба америкийн стандартад (загварт) тохирохгүй зан төлөв (стереотип) гэрлэлтийн хэлбэр, ёс заншил зэрэг нь бусдын соёлд ердийн зөв хэм хэмжээ байдаг билээ

Тухайлбал, полигами, полиандри, инициаци г.м. Европ, америкийн ёс суртахууны ойлголт, зарчмыг туйлын ганц зөв хөгжил гэж хэн ч тулгах эрхгүй, тэр бол харьцангуй зүйл. Жишээ нь, европ ба америкад полигамийг (хэдэн эхнэрт гэрлэлт) олон нийт шүүмжилж, хуулиар хориглосон байхад Дагомээд эцгийн эрхт ёсны полигами гэр бүл нь хууль ёсны, ердийн хэм хэмжээ, нийгмийн шинжтэй байна. Дагомейчүүдийн хувьд олон эхнэрт гэрлэлт бол олон зууны түүхээр түүний аж ахуйн нөхцөлд үр ашигтай соёлын сайн зүйл байна.

М.Херцсковицийн соёлын релятивизмын нэгэн үндсэн үзэл санаа бол соёлын үнэт зүйлсийн эрх тэгш байдлыг зөвшөөрөн хүлээх явдал юм. Тэрхүү үнэт зүйлсийг ард түмнүүд бүтээсэн, бүтээж ч байна. Иймд соёл бүхэн нь бие даасан төгс төгөлдөр үнэт зүйл, иймд евро-америкийн эрхэмсэг давамгайл соёлын үзэл үнэлэмж буюу этноцентризм ба евроцентризмаас зарчмын хувьд бүрэн татгалзах ёстой байна. Ингэснээр М.Херцсковицийн соёлын релятивизмын зарчим нь соёл судлалын онолын хүрээнээс хальж, ард түмний соёлын практик амьдралын бодит нөхцөл байдлын өнцгөөс хандсаныг оросын угсаатны зүйч С.А. Токарев онцолж: - “Хэн ч, хэзээ ч ард түмнүүдийн хувь заяанд дураар оролцох эрхгүй, тэр тусмаа тэд бие дааж хөгжиж чадахгүйгээр шалтаглан хөндлөнгөөс хутгалдах эрхгүй” (8) гэсэн үзэл санааг дэмжжээ.

М.Херцсковиц соёлын релятивизм нь агуулгыг тодорхойлсон гурван хүчин зүйлийн аспектүг тодорхойлжээ. Тэр нь: 1. *Арга зүйн аспект* нь соёлыг танин мэдэхүйд хамаарна. Ард түмэнд хэвшсэн үнэт зүйлсийн үндсэн дээр соёлыг танин мэдэх ёстой, тодруулбал бодгалийн амьдрал, үйл ажиллагааг дасан зохицсон тэр соёлын нэр томъёоллын сэтгэлгээний ойлголтын хүрээнд судлан шинжлэх шаардлагатай; 2. *Гүн ухааны аспект* нь соёлын хөгжлийн зэрэгцсэн олон хувилбартайг зөвшөөрөн хүлээхэд оршино. Соёлын хөгжлийг өрнөлтийнх нь явцад олон эшт үзэл баримтлалтай хандах ёстой. Ингэхдээ өнөөг хүртэл ноёрхсон, давамгайлж, тэргүүлсэн хөгжлийн гагц хувилбартай эволюционист онолоос зайлшгүй татгалзана; 3. *Практик үйл ажиллагааны аспект* нь хуучинсаг соёлын өвөрмөц онцлогоо сахисан нөхцөлд л аж үйлдвэржсэн соёл иргэншилд татан оролцуулах боломжтой. Ингэхдээ өвөрмөц онцлогийг нь хэрхэвч халдаж, хөндөж болохгүй. М. Херцсковицийн энэхүү үзэл баримтлал хичнээн үр ашигтай болох нь өнөө бидний цагт мэдэгдэхүйц мэдрэгдэж байна. Хоцрогдсон буурай ард түмний соёлыг хөндөж зохиомол шинэ соёлын нөхцлийг бүрдүүлэх явдал нь тэдний соёлыг доройтуулан мөхөөх, эсвэл архидалт, хулгай дээрэм зэрэгт хөтөлж байна. Иймд өрнөдийн бус соёлд маш анхааралтай, тэвчээртэй хандах ёстой. Харин тэдгээрийн соёлын ололт амжилтыг орчин цагийн аж үйлдвэржсэн нийгмийн соёлд хэрхэн авч хэрэгжүүлэх арга замын асуудлыг ч бас дэвшүүлсэн байна.

М.Херцсковиц: - “Хууль эрх зүй, шударга ёс, гоо сайхан гэх мэт нь хичнээн соёл байна төчнөөн илэрхийлэл хувилбартай, тиймээс тэднийг үгүйсгэх бус, хүлцэл тэвчээртэй хандахыг зөвшөөрөн хүлээх ёстой” (9) гэжээ. Өрнөдийн бус хэв маягтай соёлын хүний амьдралын зохион байгуулалтад маш анхаарал болгоомжтой хандаж байхыг анх анхааруулсан нөхдийн нэг юм. Жишээ нь, Европ бус соёлын олон зууны практик хөгжлөөрөө хуримтлуулсан дорнын байгальд хандах туршлага ололт, ардын эмнэлэг зүй гэх мэт хамаарна. Энэ давуутай талыг С.А. Токарев тэмдэглэсэн нь: - “Хэдий хоцрогдсонд гооцогдсон ч ард түмний соёл бүхнийг хүндэтгэх, тэрхүү соёлыг бүтээгчдэд маш болгоомж анхааралтай хандах ёстой. Европ, америкийн соёлын үнэт зүйлс ертөнцийн ганц

хөгжил бадруулагч хэмээн өөрсдийгөө өргөмжилж, магтан дуулсан, ихэрхэг дээрэлхүү зан, алдаа эндэгдэлгүй шүүгчийн дүр эсгэхээс татгалзах ёстой. М. Херцсковицийн энэхүү үндэслэл нь суурьтай үндэслэлтэй, олны анхаарал татсан шинжлэх ухааны эрүүл саруул, зөв бодлого, үзэл санааных нь гавъяа мөн болох нь эргэлзээгүй юм” (10) гэжээ.

А.А.Белик соёлын релятивизмын үзэл баримтлалыг практик үйл ажиллагааны талаас үнэлж зарим эргэлзээтэй асуудлуудыг тогтоон: - “Түүхэн ба орчин үеийн соёлын зарим үзэгдэлд хэрхэн хандах вэ? Энүүхэндээ хэлбэл сөрөг, мэлзсэн агуулгатай соёлыг юу гэж үзэх вэ?! Хүн намнан идэж ундлах гэх мэт соёлыг үнэт зүйлс гэж зөвтгөж, хүндэтгэлтэй хандах уу? Тэгвэл расизмийн элдэв харгислал, тоталитар дэглэмийн үй олноор хоморголон цаазлан устгах концлагерь мэтийг яахар? Хийсвэр функциональ үзэл баримтлалаар бол эдгээр соёлууд байх чухал шаардлагатай юу? Соёлын релятивизмын хувьд дотоод хөгжлийн логик илэрхийлэл мөн үү? гэсэн асуулт тавьжээ”. Энэ асуултанд М. Херцсковиц хариулсангүй тул түүнийг “хэт өвөрмөц давтагдашгүй үнэт зүйлсийг тогтооход автагдсан дугагдалтай” (11) гэж шүүмжилжээ. Үнэхээр Шинэ Гвинейн той толгойны ангуучлал, эртний Ромын гладиаторуудын тулалдаан, фашист Германийн концлагерь гэх мэтийг соёлын үнэт зүйлсэд тооцох хэрэггүй л биз. Ер нь жинхэнэ үнэт зүйлсээс үнэт бус зүйлсийг ялган зааглаж байх ёстой. К.Клакхон бодвол энэ өнцгөөс нь харж М. Херцсковицийн үзэл баримтлалыг “дураар авирласан соёлын релятивизм” (12) гэж тодорхойлсон болов уу.

М.Херцсковицын соёлын релятивизмын бас нэгэн чухал чиглэл бол эгэл уламжлалт соёлд хандах практик хандлагыг боловсруулан тогтоох явдал байжээ. Олон зууны хоцрогдлыг даван туулахад нь туслах замаар барууны аж үйлдвэржсэн хөгжилд өдөөх үү? Эсвэл тэдгээр соёлын халдашгүй дархан байдлыг сахих уу? Нэг бол тэдгээр ард түмний соёлын өвөрмөц онцлогийг аль болохоор эвдэхгүйгээр аж үйлдвэржсэн соёл иргэншилд татан оролцуулах уу? Ямар ч тохиолдолд соёл болгонд тус тусын үнэлэмж ёсоор хандвал зохистой. Зарим соёлд халдах хэрэггүй, өвөрмөц онцлогийг нь эвдэж сүйтгэхгүйгээр аж үйлдвэржсэн ертөнцтэй холбох нь оновчтой болов уу. Эцсийн эцэст тэрхүү соёлын хөгжлийг эзэд нь тодорхойлох нь зүй ёсны билээ. Буурай ард түмний соёлыг дур мэдэн зохиомлоор бүрдүүлэх явдал ард түмний дийлэнхийг архидалт, хулгай тонуулд автуулах, эсвээс нийгмийн хөгжил замналыг нь бууран доройтуулах, адагтаа устаж мөхөхөд хүргэнэ. Ийм эмгэнэлтэй жишээ ертөнцөд хаа сайгүй л байна. Иймд М. Херцсковицийн онолын үзэл баримтлал хичнээн их үр ашигтай, чухал шаардлага хэрэгцээтэй болох нь өнөө үед мэдрэгдэхүйц ач холбогдолтой байна.

Соёлын релятивист үнэт зүйлийн үзэл санаа нь:

- ✓ Хөгжлийн түвшинг харгалзахгүй бүх соёл эрх тэгш тогтнох эрхтэй. Соёл бүхэн тодорхой нийгмийн орчинд дасан зохицох онцлог арга барил болно;
- ✓ Соёлын үнэт зүйлс нь тухайн соёлын тодорхой нөхцөл байдал, хамааран харъяалах хүрээний дотор бүрэлдэн тогтох тул харьцангуй шинжтэй;
- ✓ Соёл бүхэнд угсаатан үндэсний хэвшин тогтсон зан төлөвийн соёл (стереотип) байна, тэр нь соёлын үнэт зүйлсийн тогтолцоог бүрдүүлнэ;
- ✓ Европын соёл бол хүн төрөлхтөний соёлын хөгжлийн нэг л хувилбар юм. Бусад соёл давтагдашгүй ба өвөрмөц чанартай тул өөрийн хөгжлийн замналтай. Иймд европентризмийн зарчим нь онолын хувьд үндэслэл нотолгоогүй, нийгмийн практик талаасаа ч хор уршигтай болно.

Ишлэл авсан бүтээлүүд

1. Садохин А.П., Грушевицкая Т.Г. Этнология. – М.,2000. С.70.
2. Аверкиева Ю.П. История теоретической мысли в американской этнографии. – М.,1979. С.122.
3. Токарев С.А. История зарубежной этнографии. – М.,1978. С.288.
4. Аверкиева Ю.П. История теоретической мысли в американской этнографии. – М.,1979. С.119.
5. Белик А.А. Культурология. Антропологические теории культуры. – М.,2000. С.92.
6. Отюцкий Г.П. История социальной (культурной) антропологии. – М.,2003. С.307.
7. Белик А.А. Культурология. Антропологические теории культуры. – М.,2000. С.95.
8. Токарев С.А. История зарубежной этнографии. – М.,1978. С.298.
9. Белик А.А. Культурология. Антропологические теории культуры. – М.,2000. С.97.
10. Токарев С.А. История зарубежной этнографии. – М.,1978. С.290.
11. Белик А.А. Культурология. Антропологические теории культуры. – М.,2000. С.97.
12. Аверкиева Ю.П. История теоретической мысли в американской этнографии. – М.,1979. С.142.